

**МОНГОЛ УЛС ДАХЬ УРАНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ, АШИГЛАЛТТАЙ
ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**
(Дүн шинжилгээ)

Ц.Болормаа, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Оршил

- I. Уран ашиглалтын эрх зүйн орчин
- II. Цацраг идэвхт хог хаягдалтай холбоотой эрх зүйн зохицуулалт

Хавсралт. Ураны хайгуул, олборлолт, ашиглалт, хаягдалтай холбогдох эрх зүйн орчны мэдээлэл

ОРШИЛ***Судалгааны зорилго***

Монгол Улс дахь ураны хайгуул, олборлолт, ашиглалттай холбоотой эрх зүйн орчны өнөөгийн байдал, эрх зүйн баримт бичгүүдийн хоорондын уялдаа холбоог тодруулахыг зорьсон болно.

Хамрах хүрээ

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн сангаас олон улсын гэрээ конвенц, хууль, бодлогын баримт бичиг, Үндэсний болон засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөө, салбарын дүрэм журам гэх мэт нийт 41 эрх зүйн баримт бичиг байх бөгөөд үүнээс хууль болон бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн хүрээнд судалгааны анализ хийллээ.

Судалгааны товч

Ураны хайгуул болон олборлолт, ашиглалттай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг дараах түвшнээр ангилж болохоор байна. Үүнд:

- 1) Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц
- 2) Монгол Улсын төрөөс баримтлах бодлого
- 3) Салбарын хууль тогтоомж
- 4) Салбарын дүрэм, журам
- 5) Үндэсний болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө
- 6) Холбогдох бусад хууль тогтоомж гэсэн 6 түвшинд хамарагдаж байна. Үүнд:

Олон улсын гэрээ, конвенц-7, бодлогын баримт бичиг-5, салбарын гол хууль тогтоомж-4, салбарын үйл ажиллагаандaa баримтлах дүрэм журам-14, хөтөлбөр, төлөвлөгөө-4, холбогдох бусад хууль-7 буюу нийт 41 эрх зүйн баримт бичиг байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц нь

1. Цөмийн материалын биечлэн хамгаалалтын тухай конвенц
2. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ
3. Цөмийн ослыг нэн даруй мэдээлэх тухай конвенц
4. Цөмийн болон цацрагийн ослын үед харилцан туслалцаа үзүүлэх тухай конвенц
5. Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр

6. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан Хэлэлцээрийн нэмэлт протокол
7. Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц

Тус салбарт Монгол Улсын төрөөс баримтлах бодлого

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
- Монгол Улсын төрөөсцацрагидэвхташигт малтмал болон цөмийн энэргийн талаар баримтлах бодлого
- Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлого
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Салбарын хууль тогтоомж

1. Цөмийн энергийн тухай хууль
2. Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
3. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль
4. Хог хаягдлын тухай хууль

Салбарын дүрэм, журам

- Авто замын салбарт цөмийн хэмжүүр ашиглахад дагаж мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм
- Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ
- Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах заавар
- Барилгын материалыг цацрагийн хяналтанд хамруулах тухай журам
- Гамшигийн үед нүүлгэн шилжүүлэх журам
- Гамшигийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам
- Рентген кабинет, ионжуулагч туяа үүсгэгч аппарат төхөөрөмжийг ашиглах, сууринуулах болон рентген шинжилгээ хийх үед мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм
- Хайгуулын ажлын тайлан хүлээн авах дотоод заавар
- Хайгуулын ажлын төлөвлөгөө хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмал олборлох уул уурхайн төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авахад тавигдах үндсэн шаардлагайг ба ТЭЗҮ хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэх уулын ажлын тайланг хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэх уулын ажлын төлөвлөгөөг хүлээн авах дотоод заавар
- Цацраг идэвхт ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны дотоод заавар
- Цөмийн болон цацрагийн улсын хяналтын албаны дүрэм¹⁵⁹

Үндэсний болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө

1. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энэргийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр
2. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
3. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
4. Монгол Улсыг үйлдвэржүүлэх Үндэсний хөтөлбөр /2009-2016 он/

¹⁵⁹http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=172&Itemid=105

Холбогдох бусад хууль тогтоомж

- Ашигт малтмалын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Газрын тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль

Судалгааны тайлан: Уран ашиглалтын эрх зүйн орчин, хог хаягдалтай холбоотой эрх зүйн орчин гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэх бөгөөд үүнтэй хамаарах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн заалтуудыг түүвэрлэсэн хүснэгтийг хавсралтаар оруулсан болно.

Түүнчлэн уран ашиглалттай холбоотой эхний бүлэгт хайгуул, тусгай зөвшөөрөл, олборлолт ашиглалттай холбогдох эрх зүйн зохицуулалтын анхаарвал зохих зүйлүүдийг авч үзсэн болно.

I. УРАН АШИГЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Цацраг идэвхт ашигт малтмалын салбарын хүчин төгөлдөр үйлчилж буй бүхий л эрх зүйн баримт бичиг нь уран ашиглах үйл ажиллагаанд чиглэгдсэн байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7-д зааснаар “Ашигт малтмал ашиглах” гэдэг нь газрын гадаргуу, түүний хэвлэлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг ойлгоно гэж заасан байна. Иймд ашиглалт гэдэг ойлголтод:

- Олборлох
- Баяжуулах
- Үйлдвэрлэх
- Экспортлох буюу худалдан борлуулах үйл ажиллагаанууд багтана.

Цацраг идэвхт ашигт малтмалын салбарын эрх зүйн актуудаас Ашигт малтмалын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын төрөөс цацраг идэвхт болон цөмийн энергийн талаар бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр болон салбарын холбогдох дүрэм, журам заавар, орд ашиглалтын Хөрөнгө оруулалтын гэрээ голчлон ашиглагдана. Судалгаанд хуулийн этгээд, татвар хураамж, гааль болон бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бусад эрх зүйн зохицуулалтыг оруулаагүй болно. Иймд судалгааны энэ хэсэгт:

- Цөмийн энергийн тухай хууль
- Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
- Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр гэсэн гол 3 баримт бичгийн зохицуулалтыг нарийвчлан судлах бөгөөд холбогдох бусад эх сурвалжийн заалтыг мөн авч үзэх болно.

Түүнчлэн 2013 оны 11 сард төрийн өмчит “МонАтом” ХХК улсын хэмжээнд хэрэгжүүлж буй ураны төслүүдээс Дорнод аймгийн нутаг дахь Дулаан уул, Зөөвч овооны ордод Францын “Арева Майнз” компанитай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан байна. Тус гэрээгээр “МонАтом” компаниар төлөөлүүлсэн Монголын тал 34 хувийг эзэмшиж байгаа бөгөөд гэрээний талаарх бусад зохицуулалтыг судалгаанд хамруулах боломжгүй юм.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого: 2009 оны Улсын Их Хурлын 45 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичиг юм. Тус бодлогын баримт бичгийн 3-ийн 2 болон 3 дугаар зүйлээр ашиглалттай холбоотой төрийн бодлогыг тодорхойлсон байна. Үүнд:

3.2.Олборлолт, боловсруулалт, баяжуулалт, тээвэрлэлт:

3.2.1.цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, боловсруулах, баяжуулах, цаашид цөмийн түлшний үйлдвэр байгуулах бодлогыг үе шаттайгаараа хэрэгжүүлнэ.

3.2.2.нөөц нь тогтоогдсон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг ашиглахад төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын адиллаар тогтооно.

3.2.3.цацраг идэвхт ашигт малтмалын ордыг дагалдагч ашигт малтмалын хамт цогц байдлаар бүрэн ашиглах бодлого баримтална.

3.2.4.цацраг идэвхт агуулга өндөртэй нүүрс, нүүрсний үнс, фосфорит болон бусад ашигт малтмалаас дэвшилтэг техник технологи хэрэглэн цацраг идэвхт элементийг ялгаж ашиглана.

3.2.5.цацраг идэвхт ашигт малтмалыг хүдэр хэлбэрээр экспортлохгүй байх бодлого баримтална.

3.2.6.цацраг идэвхт ашигт малтмалаас гаргаж авсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын болон олон улсын гэрээнд нийцүүлэн гагцхүү энхийн зориулалтаар экспортлоно.

3.2.7.цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах, ашиглах, хадгалах, хаягдлыг аюулгүй болгох, тээвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн хянaltaан дор явуулна.

Цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглах нөхцөлийн хувьд энэхүү бодлогын баримт бичигт зааснаар хөрөнгө оруулагчдыг татан оролцуулсан дотоод, гадаадын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нийцсэн урт хугацааны гэрээ байгуулан, хамтран ажиллана гэж заасан бөгөөд стратегийн хөрөнгө оруулагч нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.3.2.1.Ерөнхий нөхцөл:

а/энэхүү бодлогын 1.4-т заасан нөлөө бүхий улстай харьцах тухай бодлого зарчимд нийцсэн; б/Монгол Улсын нутаг давсгэрт олборлосон цацраг идэвхт ашигт малтмалыг энхийн зорилгоор, дэлхийн зах зээлийн үнэд хургэж борлуулах чадвартай, санхүүгийн хувьд бүрэн бие даасан;

в/цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт, нөхөн сэргээлтийг хийх санхүүгийн чадавхтai;

г/цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалт, борлуулалтаар дэлхийн зах зээлд тогтвортой, тэргүүлэх байр суурь эзэлсэн;

д/үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй.

3.3.2.2.Техник технологийн хувьд:

а/цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах олон жилийн туршлагатай;

б/цацраг идэвхт ашигт малтмалын ордын нөөцийг бүрэн ашиглах тэргүүний технологитой;

в/цөмийн технологи нэвтрүүлэх чадвартай;

г/цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулахдаа эдийн засгийн илүү үр ашигтай, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй дэвшилтэг технологи ашигладаг.

3.3.2.3.Байгаль орчин, аюулгүй ажиллагааны хувьд

а/хариуцлагатай уул уурхайг хөтлөн явуулдаг, энэ талаар туршлага хуримтлуулсан;

б/уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны олон улсын стандарт, шаардлагыг хангаж ажилладаг;

в/цацраг идэвхт ашигт малтмалыг боловсруулах, ашиглахдаа хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг явуулж, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийдэг.

3.3.2.4.Нийгмийн асуудлаар:

а/бүс нутгийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачлагатай оролцдог;

б/ажиллагсдын сургалт, дадлагын асуудлыг шийдэж ирсэн туршлагатай;

в/компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаарх дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн.

Цөмийн энергийн тухай хууль: ийн 2 болон 4 дүгээр бүлгээр цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах салбар дахь төрийн зохицуулалт болон хөрөнгө оруулалтын гэрээний талаар заасан байдаг. Түүнчлэн цацраг идэвхт болон цөмийн ашиглалттай холбоотойгоор заавал хөндөгдөх сэдэв болох тусгай зөвшөөрлийн талаар энэ хуулийн 3-р бүлэгт заасан байдаг.

Тусгай зөвшөөрөл: Цацрагт идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага, түүний эрх, үүрэг, тусгай зөвшөөрөл хүсэгчид тавих шаардлага болон тусгай зөвшөөрөл олгох журам, өргөдөл гаргах журам, хугацаа түүнийг сунгах, төлбөр хураамж, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болох үндэслэл зэргийт энэ хуулийн 3-р бүлээр зохицуулсан бөгөөд дараах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр заасан байна. Үүнд:

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

15.1. Дараах үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:

- 15.1.1. Цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах;
- 15.1.2. Цөмийн төхөөрөмж ашиглах;
- 15.1.3. Цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах;
- 15.1.4. Цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах;
- 15.1.5. Цацрагт идэвхт ашигт малтмал эрэх, хайх;
- 15.1.6. Цацрагт идэвхт ашигт малтмал ашиглах;
- 15.1.7. Цацрагт идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацрагт идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх;
- 15.1.8. Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрал, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг.

Ашиглалттай холбоотой төрийн бодлого, эрх зүйн орчны хүрээнд дараах эргэлзээтэй асуудал байгааг анхаарна уу. Үүнд:

Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд зааснаар “Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох” гэсэн нь Цөмийн энергийн тухай хуулийн 15.1.1-15.1.4, 15.1.7 /дээрх хүснэгтээс үзнэ үү/ дахь заалттай зөрчилдэх байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, Цөмийн энергийн тухай хуулиар тогтоосон үйл ажиллагаа нь шар нунтагаас хэтэрсэн эсэх нь тодорхойгүй байна.

Өөрөөр хэлбэл “шар нунтагаас цааш үргэлжлэхгүй байх” гэдэг нь ямар утгыг илэрхийлж байгаа ойлголт болохыг, энэ ойлголтод цацрагт идэвхт ашигт малтмалтай холбоотой ямар ямар үйл ажиллагаа хамаарч байгаа болохыг нарийн тодорхойлох шаардлага тулгарч байна. Ямар тохиолдолд “шар нунтагаас цааш үргэлжилсэн” болохыг тодорхой тогтоох шаардлага байна.

Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль: ийн 5 дугаар зүйлд цөмийн энерги, технологи ашиглах тухай дараах заалтууд бий. Үүнд:

“5.1. Цөмийн эрчим хүч, технологийг зөвхөн цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр анагаах ухаан, уул уурхай, эрчим хүчний үйлдвэрлэл, судалгаа зэрэг гагцхүү энхийн зорилгоор Монгол Улсын олон улсын гэрээний дагуу олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн ашиглана.

5.2. Энэ хуулийн 5.1-д заасан зорилгоор болон Монгол Улсын хил орчимд хүн ам, байгаль орчны аюулгүй байдалд шууд нөлөөлөх буюу алсдаа сөргөөр нөлөөлж болзошгүй цөмийн шаар, аюултай хог хаягдал булшлах буюу хадгалуулахгүй байх талаар

Олон Улсын Атомын Энергийн Агентлаг /ОУАЭА/ болон олон улсын холбогдох бусад байгууллага, цөмийн хөтөлбөр бүхий улстай хамтран ажиллана." гэж заасан нь цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн, өөрөөр хэлбэл цөмийн хянацаа хэлбэрээс хамгаалсан эрх зүйн орны маш тодорхой хамгаалалт болсон.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр: Тус хөтөлбөрийн 2009 онд Засгийн газрын 222 дугаар тогтооолоор баталсан бөгөөд "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх, цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул хийх, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн, экспортын шинэ эх үүсвэрийг бий болгох, цөмийн энерги ашиглах замаар Монгол Улсын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор баталсан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 7 зорилт дэвшүүлсэн бөгөөд үүнээс б дахь зорилт буюу "Цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих ажлын бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Үүнд:

- 4.6.1. Цөмийн эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, олон улсын байгууллагын санал зөвлөмжийг авч ажиллах;
- 4.6.2. Цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих хөрөнгө оруулагчдыг мэргэжлийн тодорхой нөхцөл, шалгуурын дагуу сонгох;
- 4.6.3. Цөмийн эрчим хүчний эх үүсвэрийг дэд бүтцийн хамт барьж байгуулах;
- 4.6.4. Цөмийн эрчим хүч ашиглахын ач холбогдол, эдийн засгийн үр нөлөө, байгаль экологийн ашиг тусыг олон нийтэд сурталчлан таниулах;
- 4.6.5. Гадаад орнуудад цөмийн энергии ашиглаж байгаа үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, хамтын ажиллагааг хөгжүүлэх

Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергий ашиглахтай холбоотой эрх зүйн орчныг судлан үзэхэд энхийн зорилгоор ашиглах ойлголтын хүрээнд бүх үйл ажиллагааг зөвшөөрсөн байгаа нь харагдаж байна.

Цацраг идэвхт ашигт малтмал олборлохоос эхлэн баяжуулах үйлдвэр, худалдан авалт болон худалдаа, цөмийн эрчим хүчтэй холбоотой бүх асуудлыг хуулийн хүрээнд зөвшөөрсөн байна.

Монгол Улсын нэгдэн орсон Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ болон түүнд нийцүүлэн гаргасан цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль зэрэг нь энхийн зорилгоор ашиглах эрх зүйн орчны баталгаа болж байгаа юм.

II. ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Цөмийн хаягдал булшлах эсэх тухай асуудал нь өнөөдөр нийгэмд хүчтэй маргаан үүсгэж байгаа бөгөөд эрх зүйн орчны түвшинд хэрхэн зохицуулагдсаныг судалгааны энэ хэсэгт багтаав. Энэ асуудлыг судалснаар анхаарвал зохих дараах асуудал байна. Үүнд:

- a) Хаягдлын хүрээнд "цөмийн хаягдал" ба "цацраг идэвхт хаягдал" гэсэн 2 ойлголт байгаа нь хаягдлын эх үүсвэрийн хувьд өөр гаралтай ч хүрээлэн байгаа орчинд үзүүлэх үр дагаварын хувьд ижил эсэх ойлголтыг нэг мөр болгох. Нэг мөр болгох гэхийн учир хууль тогтоомж дахь "аюултай хог хаягдал" гэсэн тодорхойлолтод цацраг идэвхт хаягдал багтах бөгөөд цөмийн хаягдал гэсэн ойлголтыг нэр

томъёоны хувьд хуульчлан тогтоогоогүй боловч хууль болон хөтөлбөрүүдэд энэ нэр томъёо хэрэглэгдсэн байна. Тиймээс энэ 2 нэр томъёо нь нэг ойлголт уу, өөр өөр ойлголт уу гэдгийг хуулийн хүрээнд нэг мөр болгох нь чухал.

Түүнчлэн Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийн зохицуулалтаар цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар тусгайлан үйлдвэрлэгдсэн “цөмийн зэвсгийн хаягдал” нь дээрх 2 хаягдаас өөр ойлголт эсэхийг тодруулах.

- b) Хог хаягдлын тухай хуулийг шинэчлэн баталснаар цөмийн хаягдал булшлахтай холбоотой эрх зүйн зохицуулалт тус хуулийн хүрээнд үгүй болсон. Харин цөмийн энергийн тухай хуулиар цацраг идэвхт хаягдал болон цөмийн хаягдалтай холбоотой зөвшөөрсөн агуулгатай зохицуулалтууд байгааг тайлангийн энэ хэсэгт оруулав.
- c) Цөмийн хаягдал булшлахтай холбоотой Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт Цөмийн энергийн тухай хуулийн хаягдалтай холбоотой заалттай зэрчилдэж байна гэж үзэх үндэслэл байна.
- d) Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуульд зааснаар цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэсэн тусгай ангиллын цацраг идэвхт болон цөмийн зэвсгийн хаягдал булшлах, тээвэрлэн өнгөрүүлэхийг хориглосон байна.

Цацраг идэвхт болон цөмийн хог хаягдалтай холбоотой эрх зүйн орчныг:

- Хууль болон олон улсын гэрээ, конвенц
- Хөтөлбөр

гэсэн үндсэн 2 түвшинд судлан үзсэнийг доорх судалгааны мэдээллээс үзнэ үү.

A) Хог хаягдалтай холбоотой олон улсын гэрээ болон дотоодын хуулийн зохицуулалт

Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн аливаа хэм хэмжээнээс үзэхэд “цацраг идэвхт хог хаягдал” ба “цөмийн хаягдал”, “цөмийн зэвсгийн хаягдал” гэсэн 3 нэр томъёо хэрэглэгдэж байгаа нь харагдах бөгөөд “Цөмийн энергийн хууль”-нд **цацраг идэвхт хаягдал** гэх ойлголтыг нэр томъёоны хувьд тодорхойлон хуульчилсан бөгөөд **цөмийн хаягдал**, **цөмийн зэвсгийн хаягдал** гэх ойлголтыг тодорхойлсон эрх зүйн акт одоогоор үгүй байна.

Мөн 2012 онд шинэчлэн найруулсан “Хог хаягдлын тухай” хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт аюултай хог хаягдал гэдэгт цацраг идэвхт хаягдлыг багтаан тодорхойлсон бөгөөд цөмийн хаягдлын тухай тодорхойлолт үгүй юм.

Цөмийн энергийн тухай хуулийн 3.1.16-д “цацраг идэвхт хаягдал” гэж цацраг идэвхийн хэмжээ нь хаягдлын стандартад заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн, ямар ч төлөөв байдалд байж болох, цаашид дахин хэрэглэгдэхгүй зүйлсийг ойлгоно¹⁶⁰ гэж заасан.

Иймд энэ 2 нэр томъёогоор нэг зүйлийг нэрлэж байна уу, 2 өөр ойлголт уу, хор аюулын шинж чанаараар ялгаатай эсэх, байгаль орчин болон хүн, амьтан ургамалд үзүүлэх сөрөг нөлөө, хор уршгийн ялгаа гэх мэт асуудлыг нэг мөр болгох нь ач холдогдолтой байна.

1. Хог хаягдалтай холбоотойгоор Монгол Улсын нэгдэн орсон конвенц:

Монгол Улс 1996 оны 12 сард “Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлшуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц”-д нэгдэн орсон байна. Гэвч тус конвенцийн оршил хэсэгт зааснаар:

¹⁶⁰Цөмийн энергийн тухай хууль. 2009 он., Төрийн ордон.

Цацраг идэвхт чанартайн улмаас олон улсын хяналтын бусад систем, түүний дотор цацраг идэвхт материалд тусгайлан хэрэглэгддэг олон улсын гэрээ хэлэлцээрт хамарагдах хог хаягдлууд энэхүү Конвенцид үл хамаарна.

гэсэн нь цөмийн болон цацраг идэвхт хог хаягдлыг устгах, булшлах аливаа харилцааг зохицуулахгүй илэрхийлж байна. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон 138¹⁶¹ гэрээ, конвенцид цацраг идэвхт материалын хог хаягдалд хамаарах гэрээ хэлэлцээр байгаагүй нь одоогийн байдлаар олон улсын гэрээ, конвенцийн түвшинд цацраг идэвхт болон цөмийн хаягдлын импорт болон хадгалалтын асуудал нээлттэй гэдгийг харуулж байна.

2. Хог хаягдалын тухай хуулийн хүрээнд:

Цацраг идэвхт болон цөмийн хог хаягдлын хувьд 2000 оны 11 сарын 03-ны өдөр батлагдсан “Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хоригло, экспортлох тухай хууль”-иар зохицуулдаг байсан боловч 2012 оны 5 дугаар сарын 17-ы өдөр тус хуулийг хүчингүй болгож оронд нь “Хог хаягдлын тухай” хуулийг шинэчлэн найруулж мөн өдөр баталсан байна.

Хүчингүй болсон энэ хуулийн 3-р зүйлд аюултай хог хаягдлыг тодорхойлоод улмаар аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох гэсэн 4-р зүйлд:

4.1. Аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.
4.2. Аюултай хог хаягдлыг Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно

зэрэг цацраг идэвхт болон цөмийн хаягдал булшлахыг хориглосон заалт байсан бөгөөд Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад энэ зүйл заалтыг хассан байна.

Тодруулбал шинэчлэн найруулсан “Хог хаягдлын тухай” хуулийн 3-р зүйл буюу хуулийн нэр томъёоны тодорхойлолтын 3.1.3 дахь заалтад:

3.1.3. “аюултай хог хаягдал” гэж хүн, амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөөс байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исэлдүүлэгч, шатамхай, дэлбэрэх аюултай, цацраг идэвхтэй, халдвартай шинж чанартай хатуу, шингэн, хий хэлбэрийн хог хаягдлыг ойлгоно.

гэж тодорхойлсон боловч тус хуулийн 4-р зүйл буюу хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлоходоо:

4.1. Энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхт хог хаягдлаас бусад хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна.

гэж заасан.

Үр дагавар: Ингэснээр “Хог хаягдлын тухай” хуулийн бүх заалтууд цацраг идэвхтэй хог хаягдалд үйлчлэхгүй болж байна. Шинэчлэн найруулсан “Хог хаягдлын тухай” хуулийн 17-р зүйлийн 1 болон 2 дахь заалтад аюултай хог хаягдлыг Монгол Улсад импортоор оруулах, хил дамжуулан тээвэрлэхийг хориглосон боловч дээр хэлсэнчлэн 4-р зүйлийн 1 дэх заалтын дагуу энэ хориглолт нь цацраг идэвхт хог хаягдалд үйлчлэхгүй.

¹⁶¹<http://www.legalinfo.mn/annex/details/6?lawid=307>

3. Цөмийн энергийн тухай хуулийн хүрээнд:

Цөмийн энергийн тухай хуульд цөмийн болон цацраг идэвхт хаягдалтай холбоотой дараах заалтууд байна. З дугаар зүйлд заасан нэр томъёоны хэсэгт “цацраг идэвхт хаягдал булилах” ойлголтыг тодорхойлоходоо “... зөвхөн өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булилахыг ойлгоно”¹⁶² гэжээ.

Хуулийн 9 дүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн тухай заалтын:

- 9.1.7. Цөмийн төхөөрөмж барих газрын байршилыг сонгох;
 9.1.8. Цөмийн хаягдал, ашиглагдсан цөмийн түүшийг хүн ам, нийгэм, байгаль орчинд аюулгүй хадгалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

гэсэн заалт байгаа юм.

Энэ заалт нь судалгааны дараагийн хэсэгт гарах Засгийн газрын Хөтөлбөрийн заалтуудтай зөрчилдэж байх бөгөөд /В хэсгээс үзнэ үү/ үүнтэй ижил зохицуулалт тус хуулийн 11.3, 11.6.6, 15.1.4, 15.1.7, 15.1.8, 42-р зүйлүүдэд цөмийн болон цацраг идэвхт хаягдалтай холбоотой дараах зохицуулалт хуульчлагдсан байна.

Эдгээр зохицуулалтыг нэг бүрчлэн авч үзвэл:

11.3. Төрийн захиргааны байгууллага нь цөмийн материал, цөмийн болон ашиглагдахгүй болсон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булилах тусгай байгууламжтай байх бөгөөд уг байгууламж нь улсын онц чухал объект байна.

11.6.6. Цөмийн болон цацраг идэвхт хаягдал, цацрагийн үүсгүүрийг улсын хэмжээнд төвлөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булилах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

15. Тусгай зөвхөөрөл авах

15.1.4. Цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булилах;

15.1.7. Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булилах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх;

15.1.8. Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрал, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булилах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

42 дугаар зүйл. Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булилахад тааех үндсэн шаардлага

42.1. Цөмийн болон цацраг идэвхт материалыг хаягдал болгох, устгах, булилахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг мөрдөнө.

42.2. Цөмийн болон цацраг идэвхт материалыг улсын байцаагчийн дүгнэлт, тусгай зөвшөөрөлгүйгээр булилах, хаягдал болгохыг хориглоно.

42.3. Цацраг идэвхт хаягдлыг устгах, булилахад дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ:

42.3.1. Цацраг идэвхт хаягдлыг устгах, булилахад олон улсын болон үндэсний стандарт, дүрэм, журмыг чанд мөрдөх;

42.3.2. Цацраг идэвхт хаягдлыг устгах, булилах ажлыг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр улсын байцаагчийн хяналтын дор гүйцэтгэх.

42.4. Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

¹⁶² Цөмийн энергийн тухай хуулийн 3.1.22 дахь заалт.

Ингэж зааснаар цөмийн хаягдал булшлах хийгээд цацраг идэвхт хаягдал булшлахтай холбоотой харилцаа нь салбарын хуулийн хүрээнд зөвшөөрөгдсөн байх бөгөөд эдгээр заалт болон Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалттай зөрчилдэж байгааг судалгааны тайлангийн В хэсгээс үзнэ үү.

4. Цөмийн зэвсгээс ангиid байх тухай хуулийн хүрээнд:

Тус хуулийн нэр томьёоны хэсэгт "цөмийн зэвсэг" гэж цөмийн хянагдашгүй эрчим хүч гаргаж дайны зориулалтаар ашиглаж болох цөмийн аливаа төрлийн тэсрэх төхөөрөмжийг ойлгоно гэсэн байdag. Тэгвэл үүнтэй холбоотой цөмийн зэвсгийн хаягдал булшлах, дамжуулан тээвэрлэхийг хориглосон дараах зохицуулалт байна. Үүнд:

- 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд, гадаад улс цөмийн зэвсгтэй холбогдсон дараах үйлдэл, үйл ажиллагааг явуулах, санаачлан хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхэд оролцохыг хориглоно:
 - 4.1.1. цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх буюу бусад аргаар олж авах, эзэмших, хяналтдаа байлагх;
 - 4.1.2. цөмийн зэвсгийг байрлуулах буюу аливаа хэрэгслээр тээвэрлэх;
 - 4.1.3. цөмийн зэвсгийг турших буюу хэрэглэх;
 - 4.1.4. цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах буюу устгах.
- 4.2. Цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн цөмийн зэвсгийн эд анги, бүрэлдэхүүн, хаягдал болон бусад эд зүйлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглоно.

В) Холбогдох хөтөлбөрүүд дэх хаягдлын зохицуулалт

Засгийн газрын болон тус салбарын хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд хаягдлын талаарх дараах заалт байна. Үүнд:

"Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2-р бүлэгт:

- Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд серөг нөлөө үзүүлэх цацраг идэвхт болон химиин хорт бодисын хэрэглээг багасгаж, онцгой хорт бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг хүчтэй болгох;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал булшлахыг хориглоно;

гэж заасан нь ч тус заалт нь 2021 он хүртэл хэрэгжих "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт болон цөмийн энергийн бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийн 4.3.5-р заалт болон Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 42 дугаар зүйлийн холбогдох заалттай зөрчилдэж байна. /тайлангийн 10 дугаар нүүрэн дэх хүснэгтээс үзнэ үү/

"Монгол Улсын төрөөс цацраг идэвхт болон цөмийн энергийн бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийн 4.3.5-д:

Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн хаягдлыг хадгалах, боловсруулах байгууламж байгуулах.

гэж заасан нь хөтөлбөрүүдийн түвшинд хаягдалтай холбоотой заалтууд зөрчилдэж байна.

ХАВСРАЛТ.

Ураны хайгуул, олборлолт, ашиглалт, хаягдалтай холбогдох эрх зүйн орчны мэдээлэл

1. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИИ			
№	Конвенцийн нэр, нэгдэн орсон огноо	Үндсэн зохицуулалт	Тайлбар
1	Цөмийн материалын биечлэн хамгаалалтын тухай конвенц 1986 онд нэгдэн орсон	<p>Энэхүү конвенцид оролцогч улсууд цөмийн энергийг энх тайвны зорилгоор хөгжүүлэх, хэрэглэх бүх улсын эрх, цөмийн энергийг энх тайвны зорилгоор хэрэглэснээс үүдэх ашиг олох тэдгээрийн хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, цөмийн энергийг энх тайвны зорилгоор ашиглах олон улсын хамтын ажиллагаанд тус дэхем үзүүлэх шаардлагатай гэдэгт итгэж, цөмийн материалыг хууль бусаар эзэмшиж ашигласнаас гарч болох ослоос урьдчилан сэргийлэхийг эрмэлзэж, цөмийн материалыг холбогдолтой гэмт хэрэг бол ноцтой сэтгэл түвшээсэн зүйл бөгөөд ийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлах, шийтгэх үр дунттай, зохих ёсны арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай гэдэгт итгэж, оролцогч улс бүрийн үндэсний хууль тогтоомж, энэхүү конвенцийн дагуу цөмийн материалыг биечлэн хамгаалах үр дунттай арга хэмжээ боловсруулахын тулд олон улсын хэмжээнд хамтран ажиллах шаардлагатай байгааг ухамсарлаж, энэхүү конвенц цөмийн материалыг аюулгүй зөөвөрлөхэд тус дэхем үзүүлнэ гэдэгт итгэж, дотоодын хэрэгцээнд ашиглах, хадгалах, тээвэрлэхэд цөмийн материалыг биечлэн хамгаалахын чухлыг мөн цохон тэмдэглэх, цэргийн зорилгоор ашиглаж буй цөмийн материалыг үр дунттай биечлэн хамгаалахын чухлыг хүлээн зөвшөөрч, ийм материал нь биечилсэн хатуу чанд хамгаалалтад байгаа хийгээд цаашид энэ хэвээр байх ёстойг ойлгож, дараах зүйлийг хэлэлцэн тохирив.</p>	
2	Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ 1963 он	<p>Энэхүү гэрээнд оролцогч цөмийн зэвсэгтэй улс гүрэн бүр цөмийн зэвсэг буюу цөмийн бусад дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэл, мөн ийм зэвсэг буюу дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэлд тавих хяналтыг шууд ба шууд бусаар хэнд ч үл дамжуулах, үүний нэгэн адил цөмийн зэвсэг буюу цөмийн бусад дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэл үйлдвэрлэх буюу ямар нэгэн аргаар олж авах хийгээд ийм зэвсэг буюу дэлбэлэх төхөөрөмж хэрэгсэлд тавих хяналтыг гартаа авах явдалд цөмийн зэвсэгтүүдийг ямар нэг улсад ямар нэг замаар туслах, өөгшүүлэн дэмжих, өдөөн ятгахгүй байх үүрэг хүлээнэ.</p>	

3	Цөмийн ослыг нэн даруй мэдээлэх тухай конвенц 1987 он		Нэг тогтоолын хавсралтаар зэрэг баталсан байна.
4	Цөмийн болон цацрагийн ослын үед харилцан туслалцаа үзүүлэх конвенц 1987 он	Нэгдүгээр зүйл. Ерөнхий заалт Оролцогч улсууд өөр хоорондоо болон Олон улсын атомын энергийн агентлагтай цөмийн осол гарсан буюу цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд түүний хор уршгийг аль болох багасгаж хүний амь, эд хогшил, байгаль орчныг гадагш алдагдсан цацраг идэвхт бодисын нөлөөнөөс хамгаалахын тулд хамтран ажиллана.	
5	Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр 1972 он		
6	Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан Хэлэлцээрийн нэмэлт протокол 2001 он		
7	Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлзулахад хяналт тавих тухай Базелийн конвенц	<p>Конвенцийн үйлчлэх хүрээ Энэхүү Конвенцийн хил дамжуулан тээвэрлэх объект болох дор дурдсан хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” гэж үзнэ: а/Хог хаягдал нь нэгдүгээр хавсралтын аль нэг ангилалд орсон боловч . . . дугаар хавсралтад заасан аливаа шинж чанарыг агуулаагүй бол; б/Хог хаягдал нь /а/ хэсэгт хамаараахгүй боловч экспортлогч, импортлогч болон дамжуулан өнгөрүүлэгч Талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу аюултай тогтоогдсон буюу аюултайд тооцогддог бол. Хил дамжуулан тээвэрлэж байгаа хаягдал нь энэхүү Конвенцийн 2 дугаар хавсралт дахь аль нэг ангилалд хамаарагдаж байгаа бол түүнийг “бусад хог хаягдал” гэж үзнэ. Цацраг идэвхт чанартайн улмаас олон улсын хяналтын бусад систем, түүний дотор цацраг идэвхт материалд тусгайлан хэрэглэгддэг олон улсын гэрээ хэлэлцээрт хамаарагдах хог хаягдлууд энэхүү Конвенцид үл хамаарна. Далайн тээврийн хэрэгслийн хэвийн үйл ажиллагааны явцад гардаг болон олон улсын эрх зүйн бусад баримт бичигт тусгагдсан хог хаягдлууд энэхүү Конвенцид мөн үл хамаарна.</p>	Монгол Улсын нэгдэн орсон энэхүү гэрээгээр цацраг идэвхт хог хаягдал энэхүү гэрээний үйлчлэх хүрээнээс гадуур байгаа бөгөөд ингэснээр Цацраг идэвхт хог хаягдлын талаарх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ			
№	Баримт бичгийн нэр, огноо	Үндсэн зохицуулалт	Тайлбар
1	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	<p>3.2.4. Эрчим хүч, эрдэс баялагийн салбарын бодлого</p> <p>3.2.4.1. Эрдэс баялагийн салбарыг хөгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын баталгааг хангахыг чухалчилж, түүхий эдийн хавсарга, гадаад, дотоодын улс төр, бизнесийн ашиг сонирхлын сэргэлдэвний талбар болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлнэ. Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, орлогод тавих хяналтыг сайжруулана.</p> <p>3.2.4.4. Цөмийн эрчим хүчиний салбарыг үндэсний ашиг сонирхол, энхийн зорилгоор ашиглах зарчимд нийцүүлэн хөгжүүлнэ. Цөмийн циклийг хөгжүүлж, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, боловсруулалт, хөрвүүлэлт, баяжуулалт, эрчим хүчиний үйлдвэрлэлийг бий болгож, бэхжүүлнэ.</p> <p>3.5.4. Хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах</p> <p>3.5.4.3. Хог хаягдаас эрчим хүч, нөөц баялаг, түүхий эд бий болгох технологи бүхий үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ. Аюултай хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож хортой, аюултай хаягдал хуримтлагдахаас сэргийлнэ.</p> <p>3.5.4.5. Химиийн хорт болон аюултай бодис, биологийн гаралтай материал, ионжуулагч цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмалтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хяналтын чадавхыг бэхжүүлнэ.</p>	Үзэл баримтлалын урантай холбогдох эдгээр заалт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудтай зөрчилдэх байна.
2	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринласан Үндэсний хөгжлийн цогц бодлого	<p>5.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого</p> <p>5.2.1.1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого</p> <p>Өндөр технологт тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглаж, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж, эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулж, мэдлэгт сууринласан эдийн засгийг бий болгох санхүүгийн чадамж, хуримтлалыг бүрдүүлнэ.</p> <p>Нэгдүгээр үе шат (2007-2015 он):</p> <p>Стратегийн зорилт 1. Стратегийн орд газруудыг ашиглана. Улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тоогосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлагх бодлогыг баримтална:</p> <ul style="list-style-type: none"> • Оюу толгойн зэс, алтны, Цагаан суваргын зэсийн, Таван Толгойн нүүрсний, Асгатын мөнгөнийн, Цавын полиметаллын, Төмөртэйн төмрийн худрийн, Чойр-Нялгын нүүрс, битумын, Цайдамын хүрэн нүүрсний, Мардай, Гурванбулагийн ураны болон бусад томоохон стратегийн орд газруудыг ашиглаж эхлэх; • Эдийн засгийн хувьд үр ашиг багатай ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх; 	

3	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого	<p>8 зүйл бүхий бодлогын баримт бичиг бөгөөд</p> <ul style="list-style-type: none"> Нийтлэг үндэслэл Бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зарчим Цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, олборлолт, боловсруулалт, тээвэрлэлт Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагаа Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа Эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, хүний нөөц Эрх зүйн орчин <p>Салбарын удирдлага, зохион байгуулалт, хамтын ажиллагаа гэсэн үндсэн 8 зүйлд тус баримт бичгийн зохицуулалт багцлагдсан бөгөөд судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.</p>	
4	Монгол Улсын төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого /2014-2025/	<p>4 зүйл бүхий бодлогын баримт бичиг нь бүх төрлийн эрдэс баялагийн хайгуул, олборлолт, ашиглалт, үйлдвэрлэлд хамаарах ерөнхий бодлогыг тодорхойлсон бөгөөд цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт, үйлдвэрлэлийн талаар нэр цохсон зохицуулалт үгүй.</p> <p>3.2.2.6.-д Монгол Улсад гүйцэтгэж байгаа төрөл бүрийн геологийн судалгаа /байгалийн рашаан, гидрогеологийн судалгаа, байгалийн хий, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмал, инженер геологи гэх мэт/ны мэдээлэл, нөөц, үр дүнгийн тайлланг үндэсний геомэдээллийн нэгдсэн санд хамруулж улсын бүртгэлд авах тухай заасан бөгөөд бодлогын баримт бичгийн бусад заалтууд бүх төрлийн эрдэс баялагийн салбарт баримтлагдана.</p>	Ерөнхий зохицуулалт бүхий эрдэс баялагийн салбарын бодлого
5	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	<p>Зорилт-11. Агаарын бохирдол, орчны доройтлыг бууруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэн, газар нутгийн тусгай хамгаалалтын үйл ажиллагааг бэхжүүлнэ.</p> <p>11.2. Аюултай хог хаягдлыг устгах байгууламж байгуулах, хогийн төвлөрсөн цэг байгуулах бэлтгэл хангах;</p>	Хог хаягдлын тухай хуулиар аюултай хог хаягдал гэдэг ойлголтод цацраг идэвхт хаягдал багтана.

3. ХУУЛЬ

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Тайлбар
1	Цөмийн энергийн тухай хууль 2009 он	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	
2	Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2009 он	1. Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2009 оны 11 дүгээр сарын 15-ны дотор уг хуульд заасан нөхцөл, журмын дагуу шинэчлэн бүртгэнэ.	

3	<p>Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль 2000 он</p>	<p>1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад чухал хүчин зүйл болох Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь, түүний дотор агаар мандал, газар, ус, газрын хэвлэлийг цемийн зэвсгээс ангид байгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд, гадаад улс цемийн зэвсэгтэй холбогдсон дараах үйлдэл, үйл ажиллагааг явуулах, санаачлан хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхэд оролцохыг хориглоно:</p> <p>4.1.1. цемийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх буюу бусад аргаар олж авах, эзэмших, хяналтдаа байлгах;</p> <p>4.1.2. цемийн зэвсгийг байрлуулах буюу аливаа хэрэгслээр тээвэрлэх;</p> <p>4.1.3. цемийн зэвсгийг турших буюу хэрэглэх;</p> <p>4.1.4. цемийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах буюу устахаа.</p> <p>4.2. Цемийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн цемийн зэвсгийн эд анги, бүрэлдэхүүн, хаягдал болон бусад эд зүйлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглоно.</p>	
4	<p>Ашигт малтмалын тухай хууль 2006 он</p>	<p>4.1.2.“цацраг идэвхт ашигт малтмал” гэж уран болон торийн булийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялагийн хуримтлалыг;</p>	
5	<p>Хог хаягдлын тухай хууль 2012 он</p>	<p>1.1.3. “аюултай хог хаягдал” гэж хүн, амьтан, ургамлыг өвчлүүлэх, гэмтээх, тэдгээрийн үр удамд хор хөнөөл учруулах болон байгаль орчны хэвийн төлөв байдалд сөрөг нөлөөтэй хортой, идэмхий, исслдүүлэгч, шатамхай, дэлбэрэх аюултай, цацраг идэвхтэй, халдвартай шинж чанартай хатуу, шингэн, хий хэлбэрийн хог хаягдлыг ойлгоно.</p> <p>4.1.Энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхт хог хаягдлаас бусад хог хаягдлайт холбогдсон харилцааг зохицуулна.</p>	
6	<p>Хөрөнгө оруулалтын тухай хууль 2013 он</p>	<p>4.7. Цемийн энергийн салбарт хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахад энэ хуулийн 20 дугаар зүйл хамаарахгүй бөгөөд уг харилцааг Цемийн энергийн тухай хуулиар² зохицуулна.</p>	
7	<p>Эрчим хүчний тухай хууль 2001 он</p>	<p>2.3.Цемийн эрчим хүч ашиглахтай холбогдсон харилцааг Цемийн энергийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.</p> <p>3.1.23.“цемийн эрчим хүчний нөөц” гэж эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор цемийн эрчим хүчний эх үүсвэрт ашиглаж болох цемийн түлшийг;</p> <p>3.1.24.“цемийн эрчим хүч” гэж цемийн эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгтээнд зориулан үйлдвэрлэсэн эрчим хүчийг;</p> <p>3.1.25.“цемийн эрчим хүчний эх үүсвэр” гэж цемийн эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгтээнд зориулж эрчим хүч үйлдвэрлэх байгаа байгууламжийг;</p> <p>4-р зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх</p> <p>4.1. Улсын Их Хурал эрчим хүчний талаарх төрийн бодлогыг тодорхойлж, цемийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.</p>	

4. ХӨТӨЛБӨР			
№	Хөтөлбөрийн нэр, огноо	Холбогдох зохицуулалт	Тайлбар
1	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр 2012 он	<p>1. АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дараах бодлогыг хэрэгжүүлнэ:</p> <p>Эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар дараах зорилтыг хэрэгжүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах; 2. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг <i>идэвхт болон химиин хорт бодисын хэрэглээг багасгаж, онцгой хорт бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг хүчтэй болгох</i>; - Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал бууллахыг хориглоно; - Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох 	
2	Монгол Улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2012 он	<p>43.6 Гурванбулаг, Дорнод, Хараат, Хайрхан, Гурвансайхан, Өлзийт, Дулаан-Уул, Зөөвч овоо ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.</p> <p>43.7 Цацраг идэвхт ашигт малтмалын орд газруудыг тушиглан Дорноговь, Дундговь, Дорнод аймгуудад боловсруулах үйлдвэр барьж байгуулах ажлыг зохион байгуулна</p> <p>43.8 Цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажлуудын үр дүнг нэгтгэж, олон улсын жишигт хүрсэн, стандартын шаардлагад нийцэн, ундээний мэдээллийн санг бүрдүүлнэ.</p> <p>268 Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал бууллахыг хориглох</p> <p>268.1 Ашигласан тулш болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй байдлын тухай конвенцид нэгдэн орж Цөмийн хаягдлын талаар Монгол Улсын баримталж байгаа бодлого, хууль эрх зүйн холбогдох баримт бичгийн хэрэгжилтийн хангана.</p> <p>268.2 Хилийн боомтууд дахь цацрагийн хяналтын техник, тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, хүний нөөцийн чадавхийг сайжруулна.</p> <p>269 Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох</p> <p>269.1 Монгол Улсын төреөс цацраг идэвхт ашигт малтмал, цөмийн энергийн талаар баримтлах бодлого, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулна.</p>	

		Хөтөлбөрийн зорилго. 2.1.Хөтөлбөрийн зорилго нь “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, эрэл, хайгуул хийх, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэн, экспортын шинэ эх үүсвэрийг бий болгох, цөмийн энерги ашиглах замаар Монгол Улсын эрчим хүний аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжлийн нөхцөлийг бурдуулэхдээ оршино.	
3	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр /2009-2021 он хүртэл/	4.3.3. Цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, баяжуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх, олон талын оролцоотой үйлдвэр байгуулах 4.3.5. Цацрагийн үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн хаягдлыг хадгалах, боловсруулах байгууламж байгуулах 4.3.6. Цөмийн эрчим хүчиний эх үүсвэрийг дэд бүтцийн хамт барьж байгуулах	Тус хөтөлбөр нь 8 зүйлтэй, 2021 он хүртэл хэрэгжинэ. Үүнээс анхаарвал зохих заалтыг түүн оруулсан ба учир нь уг хөтөлбөрийн заалтууд Засгийн газрын 2012-2016 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөрийн заалттай зөрчилдэж байна.
4	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр /2009-2016 он/	Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ 14.25 Цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, баяжуулах үйлдвэр байгуулах.	

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ**Олон улсын гэрээ, конвенци:**

- Цөмийн материалын биечлэн хамгаалалтын тухай конвенц. 1986 он.
- Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай олон улсын гэрээ. 1963.
- Цөмийн ослыг нэн дариу мэдээлэх тухай конвенц. 1987он.
- Цөмийн болон цацрагийн ослын үед харилцан туслалцаа үзүүлэх тухай конвенц 1987он.
- Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдсон баталгааг хэрэглэх тухай хэлэлцээр. 1972 он.
- Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан Хэлэлцээрийн нэмэлт протокол. 2001 он.
- Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлшулахад хяналт тавих тухай Базелийн конвенц. 1996 он.



Хууль:

8. Цөмийн энергийн тухай хууль
9. Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
10. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль
11. Хог хаягдлын тухай хууль
12. Ашигт малтмалын тухай хууль
13. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
14. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
15. Газрын тухай хууль
16. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
17. Эрчим хүчний тухай хууль
18. Хөрөнгө оруулалтын тухай хууль

Бодлогын баримт бичиг:

19. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
20. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц бодлого
21. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
22. Эрдэс баялагийн салбарт төрөөс баримтлах бодлого
23. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Хөтөлбөр:

24. Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогыг хэрэгкүүлэх хөтөлбөр, 2009
25. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2012
26. Монгол Улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2012
27. Монгол Улсыг үйлдвэржүүлэх Үндэсний хөтөлбөр /2009-2016 он/

Ашигласан мэдээллийн сан:

28. УИХ-ын Тамгын газрын дотоод сүлжээний хуулийн сан
29. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn
30. Цөмийн энергийн газрын вэб хуудас:
http://nea.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=52&Itemid=108
31. Засгийн газрын вэб хуудас: www.zasag.mn

